



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/146/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас:88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
<b>Аудитын тайлан</b> .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
<b>Менежментийн захидал</b> .....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ШИНЭЖИНСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Д.НАСАНЖАРГАЛ ТАНАА 7

2020.02.21 № 1/180

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:/бичиг хэрэг 2020-Албан тоот А4/

005020130

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, төсвийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад эмийн зардлаас 6,9 сая төгрөгийг шилжүүлсэн 3,9 сая төгрөгийг авлагаар тайлагнаагүй зардалд бүртгэсэн, 2019 оны жилийн эцсийн тооллогыг бүрэн хийж, үр дүнг хэлэлцэж, тооцоог бодож баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг ... жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

D:/бичиг хэрэг 2020-Албан тоот А4/

## Аудитын тайлан

### 4.1 2.1. Оршил

4.2 Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Насанжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.18-аас 2020.02.19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.20-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.25-ний өдөр, аудит хийлгэх хүсэлтээ 2019.12.12-ний өдрийн 109 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.3 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### 4.4 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэргэжлийн эвсэг хамт олны оролцоотойгоор эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг аюулгүй, эрсдэлгүй, орчинд, чанартай үзүүлж өвчлөл эндэгдлийг тууштай бууруулна.

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллагын ажлын хариуцлага, тусламж үйлчилгээний чанарт сөрөг нөлөө технологийн зөрчил зөрчил, хариуцлагагүй байдал, ёс суртахууны доголдлыг гаргахгүй байх.
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, хүн амын эрүүл мэндийн бодит байдал, хэрэгцээ, шаардлагыг хэтийн төлөвтэй уялдуулан давуу талтай ажиллана.
- Эмнэлгийн барилга, байгууламж, багаж төхөөрөмжийн засвар шинэчлэл хийх замаар үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх
- Эмнэлгийн удирдлагын менежментийг боловсронгуй болгож эрүүл мэндийн тусламжийн чанар сайжруулах
- Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж, тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ гэж үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### 4.5 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### 4.6 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 31 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

#### 4.7 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин-г “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 393064,4 мянган төгрөгөөс тооцон 7861,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин-г үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгийн 2% буюу 7861,2 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

#### 4.8 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187541,5 мянган төгрөгөөр буюу 13,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	-	-	-
<b>Авлага</b>		4,446.50	4,446.50
<b>Урьдчилгаа</b>	-	-	-
<b>Бараа материал</b>	42,457.70	41,568.30	-889.40
<b>Үндсэн хөрөнгө</b>	717,514.40	764,051.20	46,536.80
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	-105,163.30	-108,754.60	-3,591.30
<b>Нийт хөрөнгө</b>	654,808.80	701,311.40	46,502.60
<b>Өр төлбөр</b>	103.50	423.10	319.60
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	654,705.30	700,888.30	46,183.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	654,808.80	701,311.40	46,502.60

Авлага дансны үлдэгдэлд 4446,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2019.12.25 ний өдөр “Монос Баянхонгор”ХХК-д тест, урвалж бодис, эмийн үнэ 6918,8 мянган төгрөгийг шилжүүлж 530,7 мянган төгрөгийг авлагаар тусгаж, 3915,8 мянган төгрөгийн материалыг хүлээж аваагүй улмаас аудитлагдсан тайланд авлагыг залруулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 889,3 мянган төгрөгөөр буурсан нь сумын ИТХ-ын 2019.05.20 ний өдрийн “Хөрөнгө акталж устгах тухай” 22 дугаар тогтоолын дагуу ашиглалтгүй байгаа 2335,7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 46536,8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10874,8 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар эмнэлгийн барилгын их засварын ажлыг 71522,1 мянган төгрөгөөр гүйцэтгэснийг капиталжуулж авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данснаас сумын ИТХ-ын 2019.05.20 ний өдрийн “Хөрөнгө акталж устгах тухай” 22 дугаар тогтоолын 35860,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан. Биет бус хөрөнгийн данс өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 319,5 мянган төгрөгөө өссөн нь нягтлан бодогч цалин төлбөр тооцоог тухай бүр хийж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллаагүй улмаас ҮЭ-133,9 мянга, цалингийн өглөг 20,0 мянга, эмийн өглөг 165,6 мянган төгрөгийн өр төлбөр үүсэн өмнөх оны ХХОАТ-ын өглөг 103,5 мянган төгрөгийг барагдуулаагүй тооцоо үүсгэж ажиллажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 700888,3 мянган төгрөг болж 46183,0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардал байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 1703,3 мянган төгрөгийн бичилт нь дахин үнэлгээний нэмэгдэлтэй үндсэн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

#### 4.9 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Шинэжинст сумын сумын Эрүүл мэндийн төв нь тайланд онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос төсөв бүрдүүлэх төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 зориулалтад 384600,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж аймгийн Засаг даргын 2019.10.28 ний өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/560 тоот захирамжаар 2435,0 мянган төгрөгийн хасах тодотгол 382165,0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 382165,0 мянган төгрөгийг улсын төсвөөс 332147,8 мянга, орон нутгийн төсвөөс 25298,6 мянга, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 24773,8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 365868,3 мянган төгрөг буюу 95,7 хувьтай байгаа нь эрүүл мэндийн даатгалаас гүйцэтгэлээр нь санхүүжүүлснээс 14534,4 мянган төгрөгийг дутуу авсан, мөн жирэмсэн амаржсаны амралттай байгаа албан хаагчдын ажлыг хавсран гүйцэтгүүлж цалин, НДШ-ын зардлаас 1381,4 мянган төгрөг, тогтмол зардлаас 372,8 мянган төгрөгийн зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

**Нэмэлт төсөв:** Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газраас 39,7 мянган төгрөгийн сорьц тээвэрлэсний зардлыг олгосон байна.

#### 4.10 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 31 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилд

тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар нийт 10600,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10600,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### 4.11 2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулах цаг хугацааны боломжгүйгээс үзээгүй болно.

#### **2.13 Шилэн дансны мэдээлэл:**

Шинэжинст сумын Эрүүл мэндийн нь төсвийн гүйцэтгэл 2,5,11,12 сард, тухай жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 2,5,10,11,12 сард, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан 1 дүгээр улиралд, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар 1.2.3.5.6.7.8.9.11.12 сард, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 2,12 сард, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 1,2,12 сард, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, 2,5,9,11,12 сард, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 1,2,3,10,11,12 сард, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 2,12 сард, бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 1,2,11,12 сард, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 2,12 сард Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Байгууллагын батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

Бүтэн жилээр тайлагнах Төсвийн гүйцэтгэлийг Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байгаа тул цаашид анхаарч ажиллах.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	5	3	1
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	28	3	1
5	Тухай бүр	8	96	60	36	
6	Нийт	27	151	100	48	3

4.12 2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

4.13 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.14 2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**“Хязгаарлалттай” дүгнэлт**

Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **3.1 Авлага**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Тайлант 2019.12.25-ний өдөр "Монос Баянхонгор" ХХК-д эмийн үнэ 3003,0 мянга, урвалж бодисын үнэ 1146,0 мянга, сорилын тестийн үнэ 2769,8 мянга 6918,8 мянга төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлсэн бөгөөд харилцагч байгууллагатай тооцоо хийгээгүй нярвын эмийн тайлан, эмийн түүвэрт эмийн үнэ 3003,0 мянган төгрөгийн эмийг орлого авч тайланд тусгасан 3915,8 мянган төгрөгийн сорилын тест, урвалж бодисыг тайланд тусгаагүй орлого авч зарлага гаргаагүй байна. Гэвч нягтлан бодогч шилжүүлсэн мөнгөн дүнгээр орлого авч зарлага гаргасны харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд авлагаар тусгуулж залруулга хийлгэсэн.

Төсөвт цалингийн сангийн зардал үлдэгдэлтэй байхад нягтлан бодох бүртгэлийг хугацаанд хөтлөөгүй улмаас ҮЭ-ын татварын өглөг 133,9, цалингийн өглөг 20,0 мянга, ХХОАТ-ын өглөгт өмнөх оны өглөг 103,5 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, мөн "Хайрхан фарм" ХХК-д 165,6 мянган төгрөгийн эмийн үлдэгдлийг төлөөгүй эмийн зардлын өглөг үүсгэж төсөв хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна

#### **3.1.2 Эрсдэл**

Хууль, журам хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, төсвийн сахилга бат алдагдах.

### **3.1.3 Өгсөн зөвлөмж**

Цаашид эм, боох материалыг хүлээн авахдаа өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийг оролцуулан комисс хүлээн авч, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хуулийн хүчин төгөлдөр анхан шатны баримтаар гүйлгээ хийж өмнөх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

**Байгууллагаас өгсөн харуу тайлбар:** Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

### **3.2 Үндсэн болон эргэлтийн хөрөнгө**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Хөрөнгө материалын үлдэгдлийг хөрөнгө материалын орлого зарлагын журналаас хөөн шалгахад сум ИТХТ-ын 2019.05.20 ний өдрийн "Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах тухай" 22 дугаар тогтоолоор 35860,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2335,8 мянган төгрөгийн аж материалыг актлах шийдвэр гарсан.

Шийдвэрийн дагуу хөрөнгийг бүртгэлээс хасахдаа үндсэн хөрөнгийг 1350,8 мянган төгрөгөөр дутуу, аж ахуйн материалыг 237,6 төгрөгийн хөрөнгөөр илүү зарлага гаргасан.

Мөн Эрүүл мэндийн төвийн даргын 2019.12.13-ний өдрийн 47 тоот тушаалаар тооллогын комисс тооллогыг үнэн зөв чанартай зохион байгуулаагүй, санхүүгийн программаас тооллогын бүртгэлийг гаргаж баталгаажуулсан, тухайн тооллогын журналаар акталж данснаас хассан хөрөнгүүдийг бэлэн байгаагаар гаргаж, тооллогын нэгдсэн дүн мэдээг гаргаж үр дүнг баталгаажуулаагүй байгаагаас хөрөнгийн үлдэгдлийн үнэн зөвийг бүрэн нотлох боломжгүй байна.

Мөн нярвын гаргасан бараа материалын тайлан нь нягтлан бодогчийн орлого зарлагын тайлангууд дүн хоорондоо зөрүүтэй, бусад хангамжийн материалын тайлан, мал амьтадын тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг ... жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" 5.1.5 "хэмжигдэхүйц байх", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05 ний өдрийн 347 тоот тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 9 "Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана" гэсэн заалтууд зөрчсөн байна.

#### **3.2.2 Эрсдэл**

Үнэн зөв, эрх үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх, санхүүгийн анхан шатны бүртгэлд тавих хяналт сул байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж**

Хөрөнгийн тооллогыг зохион байгуулахдаа үр дүнг хэлэлцэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтыг мөрдөн ажиллаж, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын дагуу бүртгэлийг хөтөлж, цаашид хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

### **3.3 Нягтлан бодох бүртгэл хөтлөлт**

**3.3.1** Нягтлан бодох бүртгэлийн бүх дансны үлдэгдэл гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлтэй тулган шалгахад бараа материалын дансны үлдэгдэл 1380,3 мянга, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1350,8 мянга, тайлант оны элэгдлийн зардал 852,4 мянга, өглөгийн данс 20,0 мянга, нийт үр дүнгийн зардал 6082,3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, тайлант хугацаанд актлагдсан 2335,8 мянган төгрөгийн бараа материалын данснаас хасахдаа үндсэн хөрөнгө худалдсаны гарзын дансаар зардлыг хорогдуулсан гэх мэт бүртгэлийн бичилтийн алдаа зөрчил илэрлээ.

